



ТӨВ АЙМГИЙН  
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/412

Зуунмод

Мал, амьтны гаралтай түүхий эд,  
бүтээгдэхүүнийг шинжилгээнд  
хамруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэд олон нийтэд эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын ард иргэдийн хүнсний хэрэгцээ (сургууль, цэцэрлэг, нийтийн хоол, цайны газар, махны зах, худалдааны цэг)-нд бэлтгэн нийлүүлж байгаа мах, сүү малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг 2022 оны 11 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд бруцеллёз өвчнийг оношлох, антибиотикийн үлдэгдэл шалгах шинжилгээнд хамруулсугай.

2. Сургууль, цэцэрлэг, нийтийн хоол, цайны газар, махны зах, худалдааны цэгүүд, үйлдвэр цехүүдийн дарга, эрхлэгч нарт ДААЛГАХ нь:

2.1.Нийтийн хүнсний хэрэгцээнд бэлтгэн нийлүүлж байгаа мах, сүүний дээжийг бэлтгэх бүрдээ аймгийн мал эмнэлгийн ариун цэврийн лабораторид илгээж шинжилгээний хариунд үндэслэн хэрэглэж, хэвших.

2.2.Эрүүл мал сүргээс бэлтгэсэн, гарал үүсэл тодорхой эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр Зуунмод сумын ард, иргэдийг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

3.Мал, амьтанд хэрэглэх эмийн зохистой хэрэглээг мэргэжил арга зүйд тулгуурлан хэрэглэж, хэвшүүлэх сургалт зохион байгуулах, сурталчлах ажлыг эрчимжүүлэхийг Мал эмнэлгийн үржлийн нэгжийн эмч (Г.Цэндсүрэн)-д даалгасугай.

4.Лабораторийн шинжилгээгээр эерэг буюу өвчтэй гарсан, антибиотикийн үлдэгдэл илэрсэн мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд хэрэглэхгүй байх, мал сүргийг эрүүлжүүлэх нөхцөл байдлаар ханган, арга хэмжээ авч ажиллахыг Мал эмнэлгийн тархвар зүйч (Э.Долгормаа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ

